



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/529

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 126 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Манхан, Дарви, Дөргөн, Цэцэг сумд болон Жаргалант сумын 3 дугаар Ерөнхий боловсролын сургууль болон 3 дугаар цэцэрлэгийн залуу багш, ажилчдын дунд зохион байгуулах урлаг, соёлын арга хэмжээний зардалд 1 7000 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагаануудад шаардагдах 1 700 000 /Нэг сая долоон зуун мянган/ төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээний 5.25-д тусгагдсан "Залуучуудын хөгжлийн дэмжих" хөтөлбөрийн зардлаас хавсралтын дагуу санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ -д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
08 дугаар сарын 14-ний өдрийн
А/529 дүгээр захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Үйл ажиллагааны зардал	Тоо ширхэг	Нэгж үнэ /төг/	Нийт /төг/
1	Манхан сумын Соёлын төвийн урлагийн арга хэмжээний зардалд	1	200000	200000
2	Дарви сумын Соёлын төвийн урлагийн арга хэмжээний зардалд	1	200000	200000
3	Цэцэг сумын Ард Аюуш соёл, урлагийн арга хэмжээний зардалд	1	500000	500000
4	Дөргөн сумын соёлын төвийн урлагийн арга хэмжээнд	1	200000	200000
5	Жаргалант сумын 3 дугаар сургуулийн урлагийн арга хэмжээ	1	200000	200000
6	Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн урлагийн арга хэмжээ	1	200000	200000
7	Цэцэг сумын соёлын төвийн урлагийн арга хэмжээний зардалд	1	200000	200000
	Нийт			1700000